# Олон насны бүлгийн анги: Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан мэдээллийн хуудас

## Олон насны бүлгийн анги гэж юу вэ?

Олон насны бүлгийн ангид нэгээс олон ангийн түвшний сурагчид хамт суралцдаг. Эдгээр ангид сургалтын хөтөлбөрийн нэг үе шатанд хамаарах сурагчид эсвэл сургалтын хөтөлбөрийн хэд хэдэн үе шатанд хамаарах сурагчид нэг дор хамрагдаж болно.

NSW мужид сургалтын хөтөлбөрийг дараах үе шатуудад хуваадаг:

**Эхний үе шат 1:** Бэлтгэл анги

**1-р үе шат**: 1-р анги болон 2-р анги

**2-р үе шат:** 3-р анги болон 4-р анги

**3-р үе шат**: 5-р анги болон 6-р анги

Сурагчид олон насны бүлгийн ангид эсвэл нэг ангийн түвшний ангид суралцаж байгаагаас үл хамааран өөрт нь хамаарах сургалтын хөтөлбөрийн үе шатны дагуу суралцана. Жишээлбэл, 1/2-р ангийн хамтарсан ангид суралцаж буй 2-р ангийн сурагч 2-р ангийн (1-р үе шат) сургалтын хөтөлбөрөөр суралцдагтай адил 4/5/6-р ангийн хамтарсан ангид суралцаж буй 4-р ангийн сурагч 4-р ангийн (2-р үе шат) сургалтын хөтөлбөрөөр суралцана.

## Манай хүүхдийн сургууль яагаад олон насны бүлгийн ангитай байж болох вэ?

Олон насны бүлгийн анги нь Австралийн сургуулиудад түгээмэл байдаг бөгөөд дараах шалтгаанаар зохион байгуулсан байж болно:

- **Элсэлтийн тооны өөрчлөлт** – Анги тус бүрийн сурагчдын тоо жилээс жилд өөрчлөгддөг. Олон насны бүлгийн анги нь сургуулиудад ангиудын сурагчдын тоог тэнцвэртэй бүрдүүлэхэд тусалдаг.
- **Боловсролын давуу тал** – Суралцах болон нийгмийн харилцааны хувьд үзүүлэх давуу талуудыг харгалзан сургуулиуд ийм бүтэцтэй ангийг зохион байгуулж болно.
- **Жижиг сургуулиуд** – Олон насны бүлгийн анги нь жижиг болон хөдөө орон нутгийн сургуулиудад түгээмэл байдаг бөгөөд ангиудыг зохих тооны сурагчтай бүрдүүлэхэд тусалдаг.


CC BY

## Сурагчдыг олон насны бүлгийн ангид хэрхэн хуваарилдаг вэ?

Сургуулийн захирал, багш нар сурагчдыг ангид хуваарилахдаа дараах зүйлсийг харгалзан үздэг:

- Сурагчийн суралцах үйл явц болон хичээлд оролцох идэвхи.
- Сургуулийн хэмжээн дэх сурагчдын олон талт бүрэлдэхүүн.
- Сурагчийн давуу тал, сонирхол болон суралцах хэрэгцээний тэнцвэртэй байдал.
- Нийгэм, сэтгэл санааны сайн сайхан байдал болон найз нөхдийн харилцаа.
- Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй заах боломж.
- Ангиудын хэмжээнд шаардлагатай тохируулга, дэмжлэгийг зохион байгуулах байдал.

Сурагчдын суралцах үйл явцыг дэмжих зорилгоор тэдний эрх ашигт хамгийн нийцсэн байдлаар ангид хуваарилдаг. Олон насны бүлгийн ангид хуваарилагдсан нь тухайн сурагч сургалтын хөтөлбөрийн үе шатны хүлээгдэж буй түвшнээс дээгүүр эсвэл доогуур түвшинд байна гэсэн үг **биш** юм.

## Олон насны бүлгийн ангид суралцах үйл явц хэрхэн явагддаг вэ?

Багш нар NSW мужийн сургалтын хөтөлбөрт үндэслэн сургалтаа төлөвлөж, сурагчдын хэрэгцээнд нийцүүлэн заах арга барилаа тохируулдаг. Үүнийг **ялгаатай хэрэгцээнд тохируулан сургах** (**differentiation**) гэж нэрлэдэг бөгөөд сурагч бүр харилцан адилгүй хурдаар суралцдаг тул энэ арга бүх ангид хэрэгждэг.

Олон насны бүлгийн ангид багш нар сурагчдын суралцах үйл явцыг ахиулахад дэмжлэг үзүүлэхийн тулд олон төрлийн арга барил ашигладаг. Үүнд:

- зарим хичээлийг бүх ангид хамтад нь хичээл заах
- сургалтын тодорхой үйл явцыг жижиг бүлгээр хуваан хэрэгжүүлэх
- сурагчдад тохирсон сорилт эсвэл дэмжлэг үзүүлэхийн тулд сургалтыг ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах
- сургалтын үйл явц, хэрэглэгдэхүүн эсвэл сурагчид сурсан мэдлэгээ хэрхэн харуулах арга хэлбэрийг тохируулах.

## Таны асуултад хариулъя

### Багш миний хүүхдэд бага анхаарал хандуулах уу?

Ангийн бүтэц нь тухайн сурагчид багш хэр их анхаарал хандуулахыг тодорхойлдоггүй. Нэг ангийн түвшний ангитай адил багш нар сурагчид суралцах явцын өөр өөр түвшинд байдгийг харгалзан хичээлээ төлөвлөдөг.

### Миний хүүхэд өмнө нь үзсэн зүйлээ дахин давтаж сурах уу?

Багш нар сурагчдын ахиц дэвшлийг хянаж, түүнд нийцүүлэн хичээлээ төлөвлөдөг. Сурагчид өөрт хамаарах сургалтын хөтөлбөрийн дагуу үргэлжлүүлэн суралцаж, шинэ мэдлэг, чадвар эзэмшихэд нь дэмжлэг үзүүлнэ.

## Миний хүүхэд найз нөхөдтэйгөө уулзаж, харилцаж чадах уу?

Сургуулиуд анги бүрдүүлэхдээ сурагчдын найз нөхдийн харилцааг харгалзан үздэг. Мөн сурагчид завсарлагааны үеэр болон сургуулийн нийтээр зохион байгуулдаг үйл ажиллагааны үеэр найз нөхөдтэйгөө уулзаж, харилцах боломжтой.

## Олон насны бүлгийн анги нь миний хүүхдэд хичээл заах арга барилд нөлөөлөх үү?

Багш нар тодорхой, шууд заах арга барилыг ашиглаж, сурагчдын суралцах явц, үнэлгээний үр дүн, давуу тал болон хэрэгцээнд үндэслэн сургалтаа тохируулдаг. Энэ нь бүх төрлийн ангид хэрэгждэг.

## Миний хүүхдэд мэдлэг, чадвараа гүнзгийрүүлэн хөгжүүлэх эсвэл өөрийн түвшинд тохирсон сорилттой даалгавар хийх боломж олдох уу?

NSW мужийн бүх улсын сургууль Боловсролын газрын “Өндөр чадавхтай болон авьяаслаг сурагчдын боловсролын бодлого”-ын дагуу өндөр чадавхтай, эсвэл онцгой авьяас чадвар бүхий сурагчдыг дэмждэг. Багш нар сурагчдын давуу тал, чадварыг тодорхойлж, түүнд нь тохирсон мэдлэг, чадварыг баяжуулах эсвэл гүнзгийрүүлэн хөгжүүлэх сургалтыг төлөвлөдөг. Энэ нь бүх төрлийн ангиудад хэрэгждэг. Олон насны бүлгийн ангид хуваарилагдсанаар эдгээр боломжийг хязгаарлахгүй.

## Олон насны бүлгийн ангид хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад хэрхэн дэмжлэг үзүүлдэг вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг ердийн эсвэл дэмжлэгт ангид суралцаж байгаагаас үл хамааран олон насны бүлгийн анги зэрэг бүх төрлийн ангид сургалтад бүрэн дүүрэн оролцоход нь дэмжлэг үзүүлдэг. Багш нар сурагч бүрийн давуу тал, хэрэгцээ болон зорилгыг таньж мэдэн, амжилттай суралцахад нь туслахын тулд ялгаатай хэрэгцээнд тохируулан заах арга, үндэслэлтэй тохируулга, шаардлагатай тохиолдолд сурагчид зориулсан сургалт, дэмжлэгийн хувийн төлөвлөгөөг ашигладаг. Эдгээр шийдвэрийг зохимжтой тохиолдолд сурагчтай өөртэй нь, мөн эцэг эх, асран хамгаалагч болон сургуулийн холбогдох ажилтнуудтай хамтран гаргадаг. Олон насны бүлгийн ангид хуваарилагдсан нь тухайн сурагчид зориулсан хувь хүний дэмжлэгийн зохицуулалтыг өөрчлөхгүй.

## Судалгаагаар юу тогтоогдсон бэ?

Өндөр чанартай сургалт нь сурагчдын суралцах үйл явцад сургуулийн орчинд нөлөөлдөг гол хүчин зүйлсийн нэг бөгөөд ангийн сурагчдын тоо, бүрэлдэхүүн болон бусад нөөцөөс илүү их нөлөө үзүүлдэг. Судалгаанаас үзэхэд сургалтыг сайтар төлөвлөж, сурагчдад зохих дэмжлэг үзүүлсэн тохиолдолд олон насны бүлгийн ангид суралцдаг сурагчдын сурлагын үр дүн нэг ангийн түвшний ангид суралцдаг сурагчдынхтай ижил түвшинд байдаг. Мөн олон насны бүлгийн анги нь сурагчдад өөр өөр нас, чадвартай үе тэнгийнхэнтэйгээ хамтран ажиллах, бусдыг ойлгож хүндэтгэх, эерэг харилцаа тогтоох чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

# Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрэв та нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл сургуулийн захиралтай утсаар холбогдоно уу. Хэрэв танд орчуулагчийн тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залгаж, өөрийн хэлний орчуулагчтай холбож өгөхийг хүснэ үү. Операторт холбогдохыг хүссэн утасны дугаараа хэлэхэд оператор орчуулагчийг шугамд холбож танд тусална. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй.